


## БАТЛАВ



**Цус Сэлбэлт Судлалын Үндэсний төв"-д оношлуур нийлүүлэх нэмэлт гэрээ.**

Дугаар № 2016 он .....

Улаанбаатар хот

Нэг талаас **Цус сэлбэлт судлалын үндэсний төв** (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас **Сетунари ХХК** (цаашид "нийлүүлэгч" гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2016 оны 10 сарын 03-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
- 1.2 Донорын тоо нэмэгдэж "Донорын цусанд халдвар илрүүлэх нуклейн хүчлийн аргын оношлуур"-ын нөөц багассантай холбогдуулан энэхүү нэмэлт гэрээг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 34.1.4-ийн дагуу байгуулахаар шийдвэрлэв.
- 1.3 Захиалагч нь Цус Сэлбэлт Судлалын Үндэсний төв"-д оношлуур нийлүүлэх №2015/01 дугаартай тендерийн **"Донорын цусанд халдвар илрүүлэх нуклейн хүчлийн аргын 2-р багцын оношлууруудыг** (цаашид "бараа" гэх) нийт **189,954,912 (нэг зуун наян есөн сая есөн зуун тавин дөрвөн мянга есөн зуун арван хоёр)** төгрөгөөр нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
- 1.4 Захиалагч нь барааны нийлүүлэлтийг нийт **189,954,912** төгрөгийн төвлөрсөн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
- 1.5 Нийлүүлэгч нь барааг 2016 оны 12 дугаар 10-ны дотор багтаан нийлүүлж хүлээлгэж өгнө.

1.6 Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

1.6.1 Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл

1.6.2 Бусад шаардлагатай баримт бичиг<sup>1</sup>;

1.6.3 Тендер ба үнийн хуваарь;

1.6.4 Гэрээний тусгай нөхцөл;

1.6.5 Гэрээний ерөнхий нөхцөл;

1.6.6 Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;

1.6.7 Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

1.7 Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

1.8 Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.

1.9 Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

### **Хоёр. Захиалагчийн эрх, үүрэг**

2.1. Захиалагч нь 1.4-т дурдсан хугацаанд нийлүүлэгдсэн барааг хүлээн авч, хүлээн авсан тухай баримт бичиг болон нийлүүлэгчийн нэхэмжлэхийг үндэслэн 20 хоногийн дотор төлбөрийг нийлүүлэгчийн данс руу шилжүүлэх үүрэгтэй.

2.2. Захиалагч нь гэрээгээр тохиролцсон төлбөр төлөх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд нэхэмжилсэн нийт үнийн дүнгийн 0.1%-тай тэнцэх алдангийг хэтрүүлсэн хоног тутамд нийлүүлэгчид төлөх үүрэгтэй.

2.3. Захиалагч нь нийлүүлэгчийн нийлүүлсэн бараа техникийн тодорхойлолтын шаардлага хангаагүй, эсвэл нийлүүлэгч нь гэрээний бусад үүргээ биелүүлээгүй тохиолдолд нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг бүхэлд нь болон хэсэгчлэн цуцлах үүрэгтэй.

---

### Гурав. Гүйцэтгэгчийн эрх үүрэг

- 3.1. Нийлүүлэгч нь гэрээний бүх нөхцөл, техникийн тодорхойлолтонд нийцсэн барааг нийлүүлэх үүрэгтэй.
- 3.2. Барааны шошго нь тендерийн материалд заасны дагуу англи хэл дээр бичигдсэн байна.
- 3.3. Нийлүүлэгч нь барааг шаардлагын дагуу зөв тээвэрлэн хүргэх нөхцөлийг хангах асуудлыг бүрэн хариуцана.
- 3.4. Нийлүүлэгч нь барааны тоо хэмжээг дутаах, нийлүүлэх хугацааг хоцроох асуудал гаргасан тохиолдолд гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээгээр хоногийн 0,1%-ийн алдангийг захиалагчид төлнө.

### Дөрөв. Хүчинтэй хугацаа

Гэрээ нь нийлүүлэгч барааг захиалагчид хүлээлгэн өгч, төлбөрийг дансаар хүлээн авч дуусах хүртэл хүчинтэй байна.

### Тав. Бусад зүйл

- 5.1. Талууд гэрээнд холбогдох асуудлаар албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.
- 5.2. Гэрээ хэрэгжүүлэхтэй холбоотой үүссэн аливаа маргааныг талууд зөвшилцлийн журмаар шийдвэрлэх ба зөвшилцөх боломжгүй болсон тохиолдолд ХАҮТ-ын дэргэдэх арбитрын шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 5.3. Уг гэрээ нь монгол хэл дээр 2 хувь хийгдсэн ба талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчинтэй болно.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний  
Төвийн Ерөнхий нягтлан бодогч Д.Гүнжээ

Хаяг: Сүхбаатар дүүрэг, Энхтайваны

өргөн чөлөө-13, С.Зоригийн гудамж

Утас: 326504, 312857, Факс: 976-11- 312857

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ :

Сетунари ХХК-ийн ерөнхий нягтлан  
н.Агиймаа

Хаяг: Хаяг: Баянгол дүүрэг 5-р хороо Ард

Аюуш

Өргөн чөлөө, гудамж

Утас:976-70177016, факс:70177016

Халдвар илрүүлэх нуклейн хүчлийн аргын оношлуурын багц №2

№	Бүтээгдэхүүний нэр	Олон улсын буюу ерөнхий нэршил	Эмийн хэлбэр	Савлалтын хэмжээ	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1.	ХДХВ1/2, гепатитын В, С вирус илрүүлэх PCR урвалж	Kit S201 cobas tagScreen MPX 2 test, version 2.96t	Оношлуурын цомог	96 шинжилгээгээр	8	9435199	75481592
2.	ХДХВ1/2, гепатитын В, С вирус илрүүлэх PCR хяналт	cobas tagScreen MPX control kit, version 2.0	Оношлуурын цомог	6 ширхэгээр	10	9435244	94352440
3.	Сорьц боловсруулах хундага	SPU	Хайрцагласан	288 ширхэгээр	10	986000	9860000
4.	К хошуу	K tip	Хайрцагласан	432 ширхэгээр	1	290000	290000
5.	s tube	S tube	Хайрцагласан	288 ширхэгээр	2	290000	580000
6.	k tube	K tube	Хайрцагласан	288 ширхэгээр	1	1360000	1360000
7.	Фильтертэй хошуу	Co-re tips with filter 1000ml	Хайрцагласан	3840 ширхэг	2	0	0
8.	Угаах уусмал	Wash reagent 5.1 l	Савтай уусмал	1 ширхэгээр	16	501930	8030880
9.	Хогын уут	Wastebag biohazard	Хайрцаг	25 ширхэгээр	7	0	0
10.	Хошууны хаягдлын хоолой	PLASTIC CHUTE (STAR), SET OF 10	Уут	10 ширхэгээр	6	0	0
	Нийт						<b>189,954,912</b>

**БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**

№	Бүтээгдэхүүний нэр	Эмийн олон улсын буюу ерөнхий нэршил	Эмийн хэлбэр	Савлалтын хэмжээ	Шаардагдаж буй хэмжээ	Нийлүүлэлтийн хуваарь
1	ХДХВ1/2, гепатитын В, С вирус илрүүлэх PCR урвалж	Kit S201 cobas tagScreen MPX 2 test, version 2.96t	Оношлуурын цомог	96 шинжилгээгээр	8	12 сарын 10
2	ХДХВ1/2, гепатитын В, С вирус илрүүлэх PCR хяналт	cobas tagScreen MPX control kit, version 2.0	Оношлуурын цомог	6 ширхэгээр	10	12 сарын 10
3	Сорьц боловсруулах хундага	SPU	Хайрцагласан	288 ширхэгээр	10	12 сарын 10
4	К хошуу	K tip	Хайрцагласан	432 ширхэгээр	1	12 сарын 10
5	s tube	S tube	Хайрцагласан	288 ширхэгээр	2	12 сарын 10
6	k tube	K tube	Хайрцагласан	288 ширхэгээр	1	12 сарын 10
7	Фильтертэй хошуу	Co-re tips with filter 1000ml	Хайрцагласан	3840 ширхэг	2	12 сарын 10
8	Угаах уусмал	Wash reagent 5.1 l	Савтай уусмал	1 ширхэгээр	16	12 сарын 10
9	Хогын уут	Wastebag biohazard	Хайрцаг	25 ширхэгээр	7	12 сарын 10
10	Хошууны хаягдлын хоолой	PLASTIC CHUTE (STAR), SET OF 10	Уут	10 ширхэгээр	6	12 сарын 10